Тус байгууллага нь 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс Стандарт хэмжилзүйн газрын нэгдсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,938.2 мянган төгрөг буюу 12.1 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 68,171.9 | 15.3% | 94,795.8 | 18.9% | 26,623.9 | 39.1% |
| Мөнгөн хөрөнгө | 2,039.2 | 0.5% | 1,292.0 | 0.3% | (747.2) | -36.6% |
| Бараа материал | 63,948.7 | 14.3% | 93,503.8 | 18.7% | 29,555.1 | 46.2% |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 378,291.3 | 84.7% | 405,605.6 | 81.1% | 27,314.3 | 7.2% |
| Үндсэн хөрөнгө | 416,121.0 | 93.2% | 682,043.9 | 136.3% | 265,922.9 | 63.9% |
| Хуримтлагдсан элэгдэл | (37,829.7) | -8.5% | (276,438.3) | -55.2% | (238,608.6) | 630.7% |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **446,463.2** | **100.0%** | **500,401.4** | 100.0% | 53,938.2 | 12.1% |
| Өр төлбөр | - | 0.0% | 40,127.8 | 8.0% | 40,127.8 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 446,463.2 | 100.0% | 460,273.6 | 92.0% | 13,810.5 | 3.1% |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн өмчийн дүн** | **446,463.2** | 100.0% | **500,401.4** | 100.0% | 53,938.2 | 12.1% |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,292.0 мянган төгрөг нь ахмадын сангийн хуримтлал бөгөөд 5,818.2 мянган төгрөгийг хуримтлуулж, 4,526.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93,503.1 мянган төгрөг болж 29,555.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр 55,277.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Стандарт хэмжилзүйн газраас 1,843.5 мянган төгрөгийн хэвлэмэл үнэт цаас, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын балансад бүртгэлтэй байсан 1,853.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 8,346.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,312.2 мянган төгрөгийн хангамжийн материал, 24,518.9 мянган төгрөгийн лабораторийн эм боох материал, 11,121.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал нийт 48,152.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Нийт 46,944.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, дуусаагүй үйлдвэрлэл данснаас 28,774.0 мянган төгрөгийн 2022 онд конторын барилгын гадна пасад хийлгэсэн зардлыг ТӨБЗГ-ын 2023 оны 07 сарын 17-ны өдрийн А-1/1373 тоот шийдвэрээр барилгыг капиталжуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 682,043.86 мянган төгрөг болж 265,922.87 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 22,279.42 мянга, дуусаагүй үйлдвэрлэл данснаас 28,774.0 мянган төгрөгөөр барилга, байгууламжийг дансыг капиталжуулсан, Монгол улсын Засгийн Газрын 2023 оны 109 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 116 дугаар тогтоолын дагуу Мэргэжлийн хяналтын газрын 191,784.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 21,085.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 2,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, нийт 214,869.4 мянган төгрөгийн өртөгтэй, 187,845.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч балансад бүртгэсэнтэй холбоотой өссөн байна.

Акталсан болон устгасан хөрөнгө байхгүй.

Өр төлбөр дансны үлдэгдэл 40,127.7 мянган төгрөг байгаа нь Монгол улсын Засгийн Газрын 2023 оны 109 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 116 дугаар тогтоолын дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зарим чиг үүрэг тус хэлтэст шилжиж ирсэнтэй холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс Мэргэжлийн хяналтын газрын байранд шилжин ирж үйл ажиллагаагаа явуулсан боловч тухайн барилгыг тус тогтоолоор эзэмшигч байгууллагыг Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний газар гаргасан учир 2023 оны төсөвт ашиглалтын зардлыг тусгаагүй, давсан орлогоос халаалтын өрийг шийдвэрлээгүйн улмаас “Хөвших Од” ХХК-д 40,127.7 мянган төгрөгийн халаалтын өртэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 460,273.6 мянган төгрөг болж 13,810.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан үр дүн 13,810.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 303,840.5 мянган төгрөг, өөрийн орлогоор 201,987.2 мянган

төгрөг, нийт 505,827.7 мянган төгрөг , нийт зарлагыг 505,827.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 85,954.3 мянган төгрөгөөр бууруулж 419,873.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн хуваарьт 2023 оны сард тодотгол хийж 22,450.0 мянган зардлыг үндсэн үйл ажиллагааны зардлаар санхүүжүүлэхээр, 2023 оны 7 сард 60,016.3 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс 55,016.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр өөрчлөлт оруулсан бол 2023 оны 10 дугаар сард 34,769.2 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс 7,219.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 27,550.0 мянган төгрөгийг нэмж санхүүжүүлэхээр тодотгож нийт 537,108.9 сая төгрөгийн зардлыг улсын төсвөөс 232,108.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 305,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 232,108.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 368,319.0 мянган төгрөг, нийт 600,427.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 63,366.0 мянган төгрөгийн давсан орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 537,061.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 537,061.9 мянган төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 0.2 мянган төгрөгөөр хэтрүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 45.5 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 1.0 мянган төгрөгөөр хэмнэж, батлагдсан төсвийг нийт 46.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **70407 Стандартчлал, хэмжилзүй** | **537,108.70** | **537,061.90** | **46.80** | **100.0%** |
| 2 | 80101 Үндсэн үйл ажиллагаа | 500,011.20 | 499,964.40 | 46.80 | 100.0% |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 33,797.50 | 33,797.50 | - | 100.0% |
| 4 | 80219 Харуул хамгаалалтын зардал | 2,550.00 | 2,550.00 | - | 100.0% |
| 5 | 80227 Лаборатори итгэмжлэл | 750.00 | 750.00 | - | 100.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын тушаалаар давсан орлогоос 28,075.7 мянга, өмнөх оны санхүүжилтээс 2,183.9 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 11,155.5 мянган төгрөг нийт 41,415.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, харуул хамгаалалтын зардалд 7,650.0 мянга, томилолт, шинжилгээний зардалд

2,525.7 мянга, 1 албан хаагчид нэг удаагийн тэтгэмж 8,000.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 9,250.6 мянга, ТӨБЗГ-т байр түрээсийн төлбөрийн 40% буюу 4,462.2 мянга, хангамж бараа материал худалдан авахад 2,346.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 7,180.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллаагааны төлөвлөгөө батлаагүй бөгөөд түлш халаалтын зардалд нийт 24,117.6 мянга, гэрэл цахилгааны зардалд 9,035.0 мянга, цэвэр бохир усны зардалд 3,873.0 мянган төгрөг батлагдсанаас Маралгүн ХХК, Хөвших од ХХК-иудтай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань-Баянхонгор”ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн

эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 395,545.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,933.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,449.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь оны эцэст халаалтын 40,127.7 мянган төгрөгийн халаалтын өртэй гарсан нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн алдаа зөрчил байхгүй.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 543,915.2 мянган төгрөгийн 46 мэдээлэл, 6.4.8 ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 44,481.4 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 2 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдааг давтан гаргасан байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж аудитаар 1,478.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 93 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 2 | 1,478.4 | 2 | 1,478.4 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **1,478.4** | **1** | **1,478.4** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй.

Аудитаар нийт 45,093.0 мянган төгрөгийн 4 зөрчил[1] илэрснээс 539.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчил арилгах 4,425.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 40,127.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт:* 2 албан хаагчийн хүүхэд асрах чөлөө дуусгавар болж үргэжлүүлэн ажлуулах тушаалаар цалин ,нэмэгдэл хөлс, урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авсан боловч 2023 оны 5 дугаар сарын нийгмийн даатгалын тайлан мэдээлэхдээ даатгуулагчийн төрлийг 06 кодоор мэдээлж шимтгэлийг зөрүүтэй мэдээлсэн. Мөн 1 албан хаагчийн 2,3,4 дүгээр сарын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг мэдээлэхдээ 786.5 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 “ажил олгогч нь орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нийгмийн даатгалын тайлан мэдээг үнэн зөв мэдээлж, залруулах 539.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоов.

### 5.2 Албан шаардлага

*1.Илрүүлэлт:* Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 4,425.3 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 21,603.1 мянган төгрөгийн и-баримтыг

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

харилцагч байгууллагаас илүү шивсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", заалтуудыг зөрчсөн байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалт " Төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Худалдан авалтын 4,425.3 мянган төгрөгийн И баримтыг 2024.03.01-ны дотор нөхөн шивүүлэх, цаашид худалдан авалтын И баримтад тавих хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

*2.Илрүүлэлт:* Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал-1, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан-1, мэдээллийг шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай, мэдээлдэг байх" заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэлт*: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн хугацаанд мэдээллийг иж бүрэн байршуулах албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж[2]

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тус байгууллагын санхүүгийн тайланд "Хөвших Од" ХХК-д 40,127.7 мянган төгрөгийн халаалтын өглөг төсөв батлагдаагүйн улмаас үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Уг өглөгийг төлж барагдуулах, цаашид Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу өр, авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| - | - | - | | | - | - | - | - | | |
| - | - | - | - | - | | | - | - | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | | |

---

[2] Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зйүлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажилчдын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын тайланд мэдээлэхдээ даатгуулагчийг кодыг буруу мэдээлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй мэдээлсэн. | 1 | 539.9 | 1 | 539.9 | | | | |
| Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 4,425.3 мянган төгрөгийн гүйлгээг Е-баримтгүй шилжүүлсэн, мөн 21,603.1 мянган төгрөгийн е баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байна. | 1 | 4,425.3 | | | 1 | 4,425.3 | | |
| Тус байгууллагын санхүүгийн тайланд халаалтын зардалтай холбоотой "Хөвших Од" ХХК-д өртэй байна. | 1 | 40,127.7 | | | | | 1 | 40,127.7 |
| **Нийт дүн** | **4** | **45,093.0** | **1** | **539.9** | **0** | **0** | **2** | **44,553.1** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроож 2 мэдээлэл байршуулсан. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | **1** | **0** | | | **1** | **0** | | |

------------оОо------------

## ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

**Байгууллагын нэр:** Стандарт хэмжилзүйн хэлтэс
**Тайлант хугацаа:** 2023 он

төгрөгөөр

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | | 5 | 6 |
| 1 | Худалдан авалт | Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 2,940.1 мянган төгрөгийн ашиглалтын зардал, 1,300.0 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцас,185.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал нийт 4,425.3 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна. 21,603,146.2 төгрөгийн Е-Баримт харилцагч байгууллагуудаас илүү шивсэн. | 4,425,320.75 | Албан шаардлага | Шивэгдээгүй байгаа дээрхи дүн бүхий төлбөрийн баримтыг 2 сарын 29-ны дотор шивж оруулах арга хэмжээг авч ажиллана. | Санал гүй | |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт | Отгондаваа, Оюунзул нарын хүүхэд асрах чөлөө дуусгавар болж үргэжлүүлэн ажлуулах тушаалаар цалин ,нэмэгдэл хөлс, урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авсан боловч 2023 оны 5 дугаар сарын нийгмийн даатгалын тайлан мэдээлэхдээ даатгуулагчийн төрлийг 06 кодоор мэдээлж шимтгэлийг зөрүүтэй мэдээлсэн. Лаборант Д.Янжиндулам 2.3.4 сарын НДШ мэдээлэхдээ 786,540 төгрөгийн дутуу мэдээлсэн. | 539,951.77 | Төлбөрийн акт | 2 сард багтаан Нөхөж мэдээлэн холбогдох суутгалыг барагдуулна. | Санал гүй | |
| 3 | Дансны өглөг | Төсөв дутуу батлагдсанаас "Хөвших од" ХХК-д халаалтын өглөгтэй байна. | 40,127,763.81 | Зөвлөмж өгөх | Тус хэлтсийн тайлбарыг ЗГ-ын хуралдааны тэмдэглэл,ЗГ-ын 2023-оны 109 дүгээр тогтоол, Стандарт хэмжил зүйн газрын шадар сайдын албанд явуулсан албан тоотын хамт хүргүүлсэн. | Санал гүй | |
| 4 | Шилэн данс | Шилэн дансанд батлагдсан төсөв, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан-2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. | | Зөвлөмж өгөх | 2024 оны шилэн дансны мэдээллийг хуацаа хоцроосон мэдээлэлгүйгээр чанартай хийж гүйцэтгэнэ. | Санал гүй | Албан шаардлага |
| 5 | НИЙТ ДҮН | | 45,093,036.3 | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.НАРАНЦЭЦЭГ

Ахлах аудитор М.АЛТАНТУЯА

Дарга, Тэргүүлэх аудитор Б.МӨНХБАТ

Стандарт хэмжилзүйн хэлтэс-ийн

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ: Н.ШАГДАРСҮРЭН

НЯГТЛАН БОДОГЧ: Д.БАЯРМАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 13/A0571206/БНА-2024/42/НА-СТА-ТШ3 Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 4,425,320 (Дөрвөн сая дөрвөн зуун хорин таван мянга гурван зуун хорь) төгрөгийн гүйлгээг и-баримтгүй шилжүүлсэн, 21,603,146 (хорин нэгэн сая зургаан зуун гурван мянга нэг зуун дөчин зургаа) төгрөгийн и-баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байна.

Өмнөх аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байхад шилэн дансны тайланд 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалт " Төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.13 дэх "мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040040

1. Худалдан авалтын 4,425,320 (дөрвөн сая дөрвөн зуун хорин таван мянга, гурван зуун хорь) төгрөгийн үнийн дүнтэй и-баримтыг 2024.03.01-ны дотор нөхөн шивүүлэх, илүү шивсэн 21,603,146 (хорин нэгэн сая, зургаан зуун гурван мянга, нэг зуун дөчин зургаа) төгрөгийн И баримтын зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 03 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1].

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга Н.Шагдарсүрэн, нягтлан бодогч Д.Баярмаа нарт даалгав[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Б.НАРАНЦЭЦЭГ

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 10/А0571206/БНА-2024/142/НА+СТА+ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын мэдээг мэдээлэхдээ хоёр албан хаагчийн 5 дугаар сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын тайлан мэдээнд даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлсэн, нэг албан хаагчийн 786,540 (долоон зуун наян зургаан мянган таван зуун дөч) төгрөгийн цалинг нийгмийн даатгалын мэдээнд дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Энэ хуулийн 4-дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, 17 дугаар зүйлийн 17.1.1 “Ажил олгогч хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дэх “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5050029

1. Албан хаагчдын 2,421,946 /хоёр сая дөрвөн зуун хорин нэгэн мянган, есөн зуун дөчин зургаа/ төгрөгийн цалинг залруулж, 786,540 /долоон зуун наян зургаан мянга, таван зуун дөчин/ төгрөгийн цалинг нөхөн мэдээлж аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн 5246025611 тоот дансанд төвлөрүүлэх[1].

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга Н.Шагдарсүрэн, нягтлан бодогч Д.Баярмаа нарт хариуцуулав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Б.НАРАНЦЭЦЭГ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."
[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."
[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно